

ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА-ИНТЕРПОЛЫН
ЭРХ ЯМБА, ДАРХАН ЭРХИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/ 

2026 оны 4 сарын 22 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

Энэхүү Ерөнхий хэлэлцээрийн Оролцогч талууд нь:

Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллага-Интерпол (цаашид "ОУЭЦБ-Интерпол" гэх) нь өөрийн Үндсэн хуульд заасны дагуу гишүүн орнуудын дотоодын хуулийн хүрээнд болон Хүний эрхийн түгээмэл тунхаглалын үзэл санаанд нийцүүлэн эрүүгийн цагдаагийн бүх байгууллага хоорондын харилцан туслалцааг аль болох өргөн хүрээнд хангах, дэмжих, мөн ердийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсооход үр дүнтэй хувь нэмэр оруулахуйц бүхий л институцийг байгуулж, хөгжүүлэх зорилготой болохыг **анхааран**,

ОУЭЦБ-Интерполын Үндсэн хуульд заасан зарчим, зорилгыг **дахин бататган**,

ОУЭЦБ-Интерполын Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу ОУЭЦБ-Интерполын бүх гишүүн орнууд нь Ерөнхий нарийн бичгийн дарга болон ОУЭЦБ-Интерполын албан тушаалтнуудыг чиг үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай бүхий л дэмжлэг, туслалцааг үзүүлнэ гэснийг **анхааран**,

ОУЭЦБ-Интерполын Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлд заасны дагуу ОУЭЦБ-Интерполын үйл ажиллагаа нь гишүүн орнуудын зүгээс тогтмол бөгөөд идэвхтэй хамтын ажиллагааг шаарддаг болохыг мөн гишүүн орнууд нь Интерполын үйл ажиллагаанд идэвх зүтгэлтэй оролцохын тулд өөрийн улсын хууль тогтоомжид нийцүүлэн, эрх хэмжээнийхээ хүрээнд боломжит бүхий л арга хэмжээг авна гэснийг **анхааран**,

ОУЭЦБ-Интерполын бүрэн эрх, үйл ажиллагаа болон ажиллагаанууд нь түүний нийт гишүүн орнуудын нутаг дэвсгэрт хэрэгждэг бөгөөд эдгээр үйл ажиллагаа, ажиллагааг явуулахад шаардагдах боловсон хүчин, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний хөдөлгөөн үүнтэй холбоотойгоор тогтмол явагддаг болохыг **анхааран**,

Гишүүн орнуудын төлөөлөгчид, ОУЭЦБ-Интерполын тодорхой байгууллагуудын гишүүд болон ОУЭЦБ-Интерполын албан тушаалтан нь тус Байгууллагын нэрийн өмнөөс чиг үүргээ бүрэн бие даасан, хараат бус байдлаар хэрэгжүүлэхэд шаардагдах эрх ямба, дархан эрхийг эдлэх ёстой болохыг мөн **анхааран**,


Эдгээр эрх ямба, дархан эрхийн зорилго нь хувь хүний ашиг сонирхлын төлөө бус харин гишүүн орнуудын төлөөлөгчид, ОУЭЦБ-Интерполын тодорхой байгууллагуудын гишүүд, болон ОУЭЦБ-Интерполын албан тушаалтнууд чиг үүргээ үр нөлөөтэй биелүүлэх нөхцлийг хангахад оршиж буйг **анхааран**,

ОУЭЦБ-Интерполын үйл ажиллагаа болон ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор эдлэх эрх ямба, дархан эрхийн хамрах хүрээг нарийвчлан тодорхойлохыг **эрмэлзэн**,

Улс орнуудын бүрэн эрхт тэгш байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улс төрийн бие даасан байдал, мөн нэг улс нөгөө улсын дотоод хэрэгт үл оролцох зарчмыг үндсэндээ хүндэтгэхээ **дахин нотлон**,

Эдгээр эрх ямба, дархан эрхийг олгох нь олон улсын цагдаагийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, хөгжүүлэхэд хувь нэмэр оруулна гэдэгт **итгэн**,

Дараахыг **хэлэлцэн тохиролцов**:



1 дүгээр зүйл

Нэр томъёоны тодорхойлолт

1. Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд дор дурдсан нэр томъёо нь дараах утга илэрхийлнэ:

- (a) “Хэлэлцээр” гэж энэхүү Ерөнхий хэлэлцээрийг ойлгоно;
- (b) “ОУЭЦБ-Интерполын архив” гэж ОУЭЦБ-Интерполын өмчлөлд байгаа, тус Байгууллагад ирүүлсэн, хүлээн авсан, боловсруулсан, эзэмшиж байгаа, үйлдвэрлэсэн, боловсруулан гаргасан, эсхүл ОУЭЦБ-Интерполоор дамжин хадгалагдаж байгаа бүх мэдээллийг ойлгох бөгөөд уг мэдээлэл нь бүртгэл, албан захидал харилцаа, цаасан баримт, баримт бичиг, гар бичмэл, гэрэл зураг, хальс, дуу болон дүрс бичлэг, компьютерын программ, видео хуурцаг, диск, өгөгдөл зэрэгт агуулагдах ба үүгээр хязгаарлагдахгүй;
- (c) “Үндсэн хууль” гэж 1956 оны 06 дугаар сарын 13-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон ОУЭЦБ-Интерполын Үндсэн хууль болон түүнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлтийг ойлгоно;
- (d) “Интерполын мэдээллийн сүлжээ” гэж ОУЭЦБ-Интерполын олон улсын цагдаагийн хамтын ажиллагааны хүрээнд өөрийн сувгаар өгөгдөл боловсруулахад ашигладаг мэдээллийн сан, харилцаа холбооны дэд бүтэц, дэвшилтэт мэдрэгч технологи болон бусад үйлчилгээг мөн эдгээрийг бүрдүүлэгч бүх төрлийн эмхэлж, цэгцэлсэн материаллаг нөөц болон программ хангамжийг ойлгоно;
- (e) “ОУЭЦБ-Интерполын тодорхой байгууллагуудын гишүүд” гэж Гүйцэтгэх хорооны гишүүд, Мэдээллийн нэгдмэл багцыг хянах комиссын гишүүд болон Интерполын зөвлөхүүдийг ойлгоно;
- (f) “ОУЭЦБ-Интерполын албан тушаалтнууд” гэж Ерөнхий нарийн бичгийн дарга болон Үндсэн хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу Интерполын ажилтны журам, дүрэмд хамаарах Ерөнхий нарийн бичгийн дарга нарын газрын ажилтнуудыг ойлгоно;
- (g) “Албан ёсны үйл ажиллагаа” гэж ОУЭЦБ-Интерполын Үндсэн хуульд заасан зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бөгөөд тус зорилгын хүрээнд хэрэгжүүлж буй аливаа үйл ажиллагааг ойлгоно;
- (h) “ОУЭЦБ-Интерполын байр” гэж өмчлөлийн хэлбэрээс үл хамааран ОУЭЦБ-Интерполын албан ёсны үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор хүлээн авагч улсын урьдчилсан зөвшөөрлийн үндсэн дээр түр эсхүл байнгын хугацаагаар зөвхөн тус Байгууллагын хэрэгцээнд ашиглаж байгаа газар, барилга байгууламж(ууд), мөн эдгээр барилга байгууламж (ууд)-ын аль нэг хэсгийг ойлгоно;
- (i) “Өмч, мөнгөн хөрөнгө, эд хөрөнгө” гэж Үндсэн хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхдээ ОУЭЦБ-Интерпол өөрийн өмчлөл, эзэмшилд байлгаж байгаа, эсхүл захиран зарцуулж буй аливаа өмч, мөнгөн хөрөнгийг ойлгоно;

Гарын үсэг /Signature/

2026 оны 4 сарын 22

Улаанбаатар

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

- (j) “Гишүүн орнуудын төлөөлөгчид” гэж ОУЭЦБ-Интерполын байгууллагуудын чуулган, эсхүл ОУЭЦБ-Интерполоос зарлан хуралдуулсан бага хурал, уулзалтад оролцохоор зохих ёсоор итгэмжлэгдсэн гишүүн улсын төлөөлөгчдийг ойлгоно;
 - (k) “Оролцогч тал” гэж энэхүү Хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгосон ОУЭЦБ-Интерполын гишүүн орныг хэлнэ;
 - (l) “Дүрэмд заасан хуралдаанууд” гэдэгт ОУЭЦБ-Интерполын Ерөнхий Ассамблейн болон Гүйцэтгэх хорооны чуулган, Бүс нутгийн бага хурал, Үндэсний төв товчоодын дарга нарын бага хурал болон Үндсэн хуульд заасны дагуу ОУЭЦБ-Интерполын бусад байгууллага болон салбар байгууллагаас зохион байгуулсан аливаа хурал, уулзалтыг оруулж ойлгоно.
2. Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд дараах нэр томъёог ОУЭЦБ-Интерполын Үндсэн хуульд заасантай адилтган ойлгоно:
- (a) Зөвлөхүүд;
 - (b) Мэдээллийн нэгдмэл багцыг хянах комисс;
 - (c) Гүйцэтгэх хороо;
 - (d) Ерөнхий ассамблей;
 - (e) Ерөнхий нарийн бичгийн дарга нарын газар;
 - (f) Үндэсний төв товчоо;
 - (g) Ерөнхий нарийн бичгийн дарга;

2 дугаар зүйл
Зорилт, зорилго

Энэхүү Хэлэлцээрийн зорилго нь Үндсэн хуульд заасан үүргийг хэрэгжүүлэх, ялангуяа олон улсын цагдаагийн хамтын ажиллагаа болон Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд заасан байгууллагуудын ажиллагааг дэмжих хүрээнд ОУЭЦБ-Интерполд эрх ямба, дархан эрх олгоход оршино. Оролцогч тал бүр ОУЭЦБ-Интерпол, түүний албан тушаалтнууд болон Үндсэн хуулийн 8, 9, 10, 11 дүгээр зүйлд заасан бусад этгээдэд ажил үүргээ ОУЭЦБ-Интерполын эрх ашгийн төлөө саадгүй, хараат бусаар, хариуцлагатайгаар хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх үүднээс энэхүү Хэлэлцээрээр тодорхойлсон эрх ямба, дархан эрхийг олгоно.

3 дугаар зүйл
Эрх зүйн субъект

1. ОУЭЦБ-Интерпол нь олон улсын эрх зүйн субъект байна.
2. Тус байгууллага нь мөн эрх зүйн чадамжтай байна, тухайлбал:
 - (a) Гэрээ, хэлцэл байгуулах;
 - (b) Хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө олж авах, захиран зарцуулах, аад харилцааны яам
 - (c) Шүүхэд нэхэмжлэл гаргах.



4 дүгээр зүйл

Хуульд заасан арга хэмжээ болон бусад ажиллагаанаас чөлөөлөгдөх дархан эрх

1. ОУЭЦБ-Интерпол, түүний өмч, мөнгөн хөрөнгө, эд хөрөнгө нь хаана байрлаж байгаа, хэн эзэмшиж байгаагаас үл хамааран доор тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүхийн болон хуульд заасан бусад арга хэмжээнээс чөлөөлөгдөх дархан эрх эдэлнэ:
 - (a) тодорхой нөхцөл байдал үүсэх тохиолдолд зөвхөн тухайн үед эдлэх дархан эрхээ ил тод байдлаар илэрхийлж, татгалзсан бол; шүүхийн харьяаллаас чөлөөлөгдөх дархан эрхээс татгалзах нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх талаар эдлэх дархан эрхээс татгалзаж байгаа хэрэг биш бөгөөд энэ талаар жич татгалзах шаардлагатай;
 - (b) 15 дугаар зүйлийн (a) хэсэгт заасан маргаан шийдвэрлэх механизмын дагуу гаргасан арбитрын шийдвэрийг албадан гүйцэтгэхтэй холбоотойгоор;
 - (c) ОУЭЦБ-Интерполын өмчлөлд байгаа эсхүл түүний нэрийн өмнөөс ашиглаж буй автотээврийн хэрэгсэл болон бусад төрлийн тээврийн хэрэгслээр осол гаргасны улмаас учирсан хохиролтой холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргасан тохиолдолд;
2. ОУЭЦБ-Интерполын байр, өмч, мөнгөн хөрөнгө болон эд хөрөнгө нь халдашгүй байна. ОУЭЦБ-Интерполын байр, өмч, мөнгөн хөрөнгө, эд хөрөнгө нь хаана байрлаж байгаа болон хэн эзэмшиж байгаагаас үл хамааран албадан гүйцэтгэх, захиргааны, шүүхийн болон хууль тогтоох үйл ажиллагаатай холбоотойгоор нэгжлэг хийх, битүүмжлэх, нөхөн төлбөргүйгээр бүр мөсөн албадан хураах, дайчлан хураах, нийтийн хэрэгцээнд зориулан хураах болон хөндлөнгийн оролцооны аливаа хэлбэрээс халдашгүй байна.

5 дугаар зүйл

Архив болон албан захидал харилцааны халдашгүй байдал

1. ОУЭЦБ-Интерполын архив нь хаана байрлаж байгаа болон хэн эзэмшиж байгаагаас үл хамааран аль ч үед, ямагт халдашгүй байна.
2. ОУЭЦБ-Интерполын албан захидал харилцаа халдашгүй байна. Тус Байгууллагын албан захидал харилцаа болон бусад хэлбэрийн харилцаа холбоог хянах, шалгах эсхүл хөндлөнгөөс бусад хэлбэрээр оролцохыг хориглоно. ОУЭЦБ-Интерпол нь нууц түлхүүр үг болон нууцлал ашиглах эрхтэй. ОУЭЦБ-Интерпол нь захидал харилцаа болон бусад харилцаа холбоог шууданч эсхүл лацадсан шуудангаар хүлээн авах, илгээх эрхтэй бөгөөд эдгээр нь дипломат элч болон дипломат шуудангийн нэгэн адил эрх ямба, дархан эрхтэй байхыг зөвшөөрнө.
3. Албан харилцаа холбооны тухайд ОУЭЦБ-Интерпол нь дипломат төлөөлөгчийн газартай нэгэн адил харилцаа холбооны сүлжээ ашигласны төлөө төлөх хураамж, татвараас чөлөөлөгдөх эрх эдлэнэ.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/ .. 

2024 оны 4 сарын 22-дөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

6 дугаар зүйл
Санхүүгийн халдашгүй байдал

1. ОУЭЦБ-Интерпол нь санхүүгийн аливаа хяналт, зохицуулалт, хориг тавьсны дагуу авч хэрэгжүүлэх хязгаарлалтад хамрагдахгүйгээр дараах эрхийг эдэлнэ:
 - (a) Аливаа төрлийн мөнгөн хөрөнгө болон гадаад валютыг хүлээн авах, эзэмших, үүнээс гадна аль ч төрлийн валютаар данс нээх, ашиглах, захиран зарцуулах; мөн
 - (b) Мөнгөн хөрөнгө болон валютыг аль ч улсын дотор, эсхүл нэг улсаас нөгөө улсад саадгүй шилжүүлэх, өөрийн эзэмшилд байгаа аливаа валютыг бусад валютад хөрвүүлэх үйлдлийг холбогдох үндэсний хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх.

7 дугаар зүйл
Албан хэрэгцээний зорилгоор татвараас чөлөөлөгдөх

1. ОУЭЦБ-Интерпол, түүний орлого, эд хөрөнгө, болон бусад өмч нь бүх төрлийн шууд татвараас чөлөөлөгдөнө. Гэхдээ ОУЭЦБ-Интерпол нь үзүүлсэн үйлчилгээний хөлс болох аливаа төрлийн татвар, хураамж, төлбөрөөс чөлөөлөгдөхгүй болно.
2. ОУЭЦБ-Интерполоос албан хэрэгцээндээ зориулан импортолсон болон экспортолсон бараа нь үндэсний хууль тогтоомжийн дагуу гаалийн татвар, импортын татвар, шууд болон шууд бус татвар, хураамж, үүний дотор нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) болон түүнтэй адилтгах үйлчлэл бүхий арга хэмжээ, мөн импорт, экспортын аливаа хязгаарлалт, хоригоос чөлөөлөгдөнө. Ийнхүү чөлөөлөлтөд хамрагдан импортолсон барааг тухайн Оролцогч талын Засгийн газартай тохиролцсоноос бусад нөхцөлөөр тус улсын нутаг дэвсгэрт худалдах, шилжүүлэх, эсхүл үнэ төлбөргүйгээр бусдад шилжүүлэх зэргээр захиран зарцуулахыг хориглоно.
3. ОУЭЦБ-Интерполын хэвлэмэл бүтээл нь гаалийн татвараас чөлөөлөгдөх бөгөөд тэдгээрийг импортлох, экспортлоход аливаа хориг, хязгаарлалт тогтоохгүй.
4. Энэхүү Хэлэлцээрийн Оролцогч талууд нь дээр дурдсан бараа болон хэвлэмэл бүтээлийг импортлох, экспортлоход шаардагдах бүх төрлийн тусгай зөвшөөрөл, лицензийг үндэсний хууль тогтоомжийнхоо дагуу олгоно.
5. ОУЭЦБ-Интерпол нь бараа, үйлчилгээ худалдан авахад төлбөрийн үнэд багтсан онцгой албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) зэрэг татвараас чөлөөлөгдөхийг ерөнхий дүрмийн дагуу шаардахгүй. Гэхдээ ОУЭЦБ-Интерпол албан хэрэгцээндээ зориулан их хэмжээний үнийн дүн бүхий худалдан авалт хийх тохиолдолд энэхүү Хэлэлцээрийн Оролцогч талууд боломжоороо онцгой албан татвар болон татварын дүнг хөнгөлөх, эсхүл буцаан олгох захиргааны зохих зохицуулалтыг хийнэ. Онцгой албан татвар болон НӨАТ-ыг буцаан олгосон (эсхүл хөнгөлсөн) барааг тухайн хөнгөлөлт үзүүлсэн Оролцогч талын Засгийн газартай тохиролцсоноос бусад нөхцөлөөр тус улсын нутаг дэвсгэрт худалдах, шилжүүлэх, эсхүл үнэ төлбөргүйгээр бусдад шилжүүлэх зэргээр захиран зарцуулахыг хориглоно.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/

2024 оны 4 сарын 24-дөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

8 дугаар зүйл


Дүрэмд заасан хурал, уулзалтуудад оролцохоор зорчих

1. Аливаа Оролцогч талын эрх бүхий байгууллагууд Дүрэмд заасан хуралдаануудад оролцох зорилготой доор дурдсан этгээдүүдийг өөрийн нутаг дэвсгэрт нэвтрүүлэх, гаргах үйл ажиллагааг хөнгөвчлөх бүх талын шаардлагатай арга хэмжээг авна. Үүнд:
 - (a) Гишүүн орнуудын төлөөлөгчид болон тэдгээрийн бүрэлдэхүүнд багтах этгээдүүд;
 - (b) Гүйцэтгэх хорооны гишүүд болон тэдгээрийн бүрэлдэхүүнд багтах этгээдүүд;
 - (c) ОУЭЦБ-Интерполын албан тушаалтнууд;
 - (d) Мэдээллийн нэгдмэл багцыг хянах комиссын гишүүд болон тус комиссын нэрийн өмнөөс албан үүрэг гүйцэтгэж буй этгээдүүд;
 - (e) Ерөнхий нарийн бичгийн дарга нарын газраас томилсон орчуулагчид болон тэмдэглэл хөтлөгчид;
 - (f) Зөвлөхүүд;
 - (g) ОУЭЦБ-Интерполын Дүрэмд заасан хуралдаан, эсхүл ОУЭЦБ-Интерполоос зарлан хуралдуулсан бага хурал, уулзалтад оролцохоор албан ёсоор уригдсан, эсхүл ОУЭЦБ-Интерполын зүгээс түүний харьяа байгууллагуудын тогтолцооны хүрээнд үүрэг гүйцэтгэхээр албан ёсоор томилогдсон ажиглагчид, шинжээчид болон бусад этгээд хамаарна.
2. Энэ зүйлийн (1) дэх хэсэгт заасан этгээдүүдэд шаардагдах виз, эсхүл улсын хилээр нэвтрэх, гарах зөвшөөрөл олгох аливаа мэдүүлгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэ төлбөргүйгээр, боломжит хамгийн богино хугацаанд шийдвэрлэнэ. ОУЭЦБ-Интерпол нь холбогдох этгээдүүд визний мэдүүлгээ зохих хугацаанд урьдчилан гаргасан байх нөхцөлийг бүрдүүлнэ.

9 дүгээр зүйл

ОУЭЦБ-Интерполын тодорхой байгууллагуудын гишүүд

1. ОУЭЦБ-Интерполын тодорхой байгууллагуудын гишүүд нь албан ёсны үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ, мөн ОУЭЦБ-Интерполоос товлосон хуралдаан болох газарт хүрэх болон буцах аяллын туршид энэхүү Хэлэлцээрийн Оролцогч талуудын нутаг дэвсгэрт дараах эрх ямба, дархан эрхийг эдэлнэ:
 - (a) Баривчлагдах буюу саатуулагдахгүй байх;
 - (b) Хувийн ачаа тээшинд үзлэг хийх, битүүмжлэхгүй байх;
 - (c) Албан үүргээ гүйцэтгэх хүрээнд хэлсэн үг, бичсэн зүйл болон үйлдсэн бүх үйлдлийнхээ төлөө хуульд заасан аливаа хэлбэрийн арга хэмжээнээс



- чөлөөлөгдөх бөгөөд энэхүү дархан эрх нь тухайн этгээд албан тушаалаа эрхлэхээ больсон тохиолдолд ч хэвээр хадгалагдана;
- (d) Оролцогч талын нутаг дэвсгэрт албан үүргээ гүйцэтгэж буй эсхүл дамжин өнгөрч буй тохиолдолд шилжилт хөдөлгөөний хязгаарлалт болон гадаадын иргэний бүртгэлээс чөлөөлөгдөх;
- (e) Хэвлэмэл эсхүл цахим хэлбэрт байгаа бүх цаасан баримт, баримт бичиг болон өгөгдлийг халдашгүй байлгах.

10 дугаар зүйл


Гишүүн орнуудын төлөөлөгчид

1. Энэхүү Хэлэлцээрийн Оролцогч талуудын холбогдох эрх бүхий байгууллагуудад зохих ёсоор мэдэгдсэн Гишүүн орнуудын төлөөлөгчид нь тухайн Оролцогч талуудын нутаг дэвсгэрт болон тэдгээртэй холбоотой харилцаанд дараах эрх ямба, дархан эрхийг албан ёсны үйл ажиллагаанд оролцох үедээ, мөн ОУЭЦБ-Интерполоос товлосон хуралдаан болох газарт хүрэх болон буцах замын туршид эдэлнэ:
- (a) Баривчлагдах буюу саатуулагдахгүй байх;
- (b) Хувийн ачаа тээшинд үзлэг хийх, битүүмжлэхгүй байх;
- (c) Албан үүргээ гүйцэтгэх хүрээнд хэлсэн үг, бичсэн зүйл болон үйлдсэн бүх үйлдлийнхээ төлөө хуульд заасан аливаа хэлбэрийн арга хэмжээнээс чөлөөлөгдөх бөгөөд энэхүү дархан эрх нь тухайн этгээд албан тушаалаа эрхлэхээ больсон тохиолдолд ч хэвээр хадгалагдана;
- (d) Оролцогч талын нутаг дэвсгэрт албан үүргээ гүйцэтгэж буй эсхүл дамжин өнгөрч буй тохиолдолд шилжилт хөдөлгөөний хязгаарлалт болон гадаадын иргэний бүртгэлээс чөлөөлөгдөх;
- (e) Хэвлэмэл эсхүл цахим хэлбэрт байгаа бүх цаасан баримт, баримт бичиг болон өгөгдлийг халдашгүй байлгах.
2. Хэрэв тухайн этгээд нь Оролцогч талын харьяат, эсхүл байнгын оршин суугч бол, эсхүл түүний төлөөлөгчөөр ажиллаж байсан бол энэ зүйлийн заалтууд нь тухайн Оролцогч талын эрх бүхий байгууллагуудад үйлчлэхгүй.


11 дүгээр зүйл

ОУЭЦБ-Интерполын албан тушаалтнууд

1. ОУЭЦБ-Интерполын албан тушаалтнууд дараах эрх ямба, дархан эрхийг эдэлнэ:
- (a) Албан үүргээ гүйцэтгэх хүрээнд хэлсэн үг, бичсэн зүйл болон үйлдсэн бүх үйлдлийн төлөө хуульд заасан аливаа хэлбэрийн арга хэмжээнээс чөлөөлөгдөх бөгөөд энэхүү дархан эрх нь тухайн этгээд ОУЭЦБ-Интерполын албан тушаал эрхлэхээ больсон тохиолдолд ч хэвээр хадгалагдана;



- (b) Шилжилт хөдөлгөөний хязгаарлалт болон гадаадын иргэний бүртгэлээс чөлөөлөгдөх дархан эрх эдэлнэ. ОУЭЦБ-Интерполын албан тушаалтнууд албан ёсны үйл ажиллагаа явуулахаар зорчиж буйг нотолсон гэрчилгээ бүхий визний мэдүүлгийг холбогдох Оролцогч талууд хууль тогтоомжийн дагуу боломжит хамгийн богино хугацаанд шийдвэрлэнэ. Түүнчлэн эдгээр этгээдийг шуурхай зорчих нөхцөл боломжоор хангана;
- (c) Тухайн улсын иргэний үндсэн үүргээс чөлөөлөгдөх;
- (d) Валютын арилжааны хувьд дипломат төлөөлөгчийн газрын ижил түвшний гишүүдийн эдэлдэгтэй адил эрх ямба эдлэх;
- (e) Олон улсын хямралын үед албан тушаалтнууд болон тэдний хамт амьдран суугаа гэр бүлийн гишүүдийн хувьд дипломат төлөөлөгчийн газрын ажилтнуудад олгодогтой адил хамгаалалт авч, буцах нөхцлөөр хангагдах;
- (f) ОУЭЦБ-Интерполоос олгож буй хөлс, үүний дотор цалин, түүний нэмэгдэл, тэтгэмж, түүнчлэн нөхөн олговор болон хохирол барагдуулах төлбөрийг бүх төрлийн татвараас чөлөөлөх.
2. Үүнээс гадна, энэ зүйлийн (1) дэх хэсэгт заасан эрх ямба, дархан эрхийг хөндөхгүйгээр, ОУЭЦБ-Интерполын Ерөнхий нарийн бичгийн дарга, эсхүл түүний эзгүйд үүргийг нь орлон гүйцэтгэж буй аливаа албан тушаалтан нь Оролцогч талын нутаг дэвсгэрт албан үүргээ гүйцэтгэх хугацаандаа олон улсын эрх зүйн дагуу тухайн Оролцогч талаас дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнд олгодог эрх ямба, дархан эрх, чөлөөлөлт болон хөнгөлөлтүүдийг эдэлнэ.
3. Энэхүү зүйлийн (1) болон (2) дахь хэсэгт заасан дархан эрхүүд нь дараах тохиолдолд үйлчлэхгүй:
- (a) Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн захиргааны зөрчил болон гэмт хэрэг;
- (b) Албан тушаалтны өмчлөлд байгаа, эсхүл түүний нэрийн өмнөөс ашиглагдаж буй автотээврийн хэрэгсэл болон бусад тээврийн хэрэгслээс үүдэлтэй ослын улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр гаргасан иргэний нэхэмжлэл.
4. ОУЭЦБ-Интерпол нь энэхүү зүйлийн зохицуулалт хамаарах албан тушаалтнуудын ангиллыг тогтоож, энэ тухай Оролцогч талуудад мэдэгдэнэ. ОУЭЦБ-Интерпол нь уг ангилалд орсон аливаа томоохон өөрчлөлтийн талаар Оролцогч талуудад мэдээлж байна.
5. Албан үүргийнхээ дагуу албан тушаалтан Оролцогч талын нутаг дэвсгэрээр зорчих, эсхүл дамжин өнгөрөх тохиолдолд ОУЭЦБ-Интерпол нь энэ талаар тухайн Оролцогч талд мэдэгдэнэ.
6. ОУЭЦБ-Интерпол нь Оролцогч талын хүсэлтээр энэ зүйлийн заалтууд хамаарах ОУЭЦБ-Интерполын албан тушаалтнуудын нэрсийг түүнд хүргүүлж болно.



7. Оролцогч талууд нь зөвхөн өөрийн харьяат болон байнгын оршин суугчдад энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн (а)-д заасан дархан эрхийг олгох үүрэг хүлээнэ. Энэ нь Оролцогч тал өөрийн мэдлээр болон үндэсний хууль тогтоомжийнхоо дагуу өөрийн харьяат, байнгын оршин суугчдад энэ зүйлийн (1) дэх хэсэгт заасан бусад эрх ямба, дархан эрхийг нэмж олгох боломжийг хөндөхгүй.

12 дугаар зүйл
Түр оршин суух эрх


Энэхүү Хэлэлцээрийн дагуу олгогдсон эрх ямба, дархан эрхийг урвуулан ашигласан гэж Оролцогч тал үзсэнээс бусад тохиолдолд, Хэлэлцээрийн дагуу олгогдсон эрх ямба, дархан эрхийг эдэлж байгаа этгээдийг албан үүргээ гүйцэтгэх хугацаанд нь Оролцогч талын Засгийн газраас өөрийн нутаг дэвсгэрээс гарахыг шаардахгүй.

13 дугаар зүйл
Аюулгүй байдал

1. Ерөнхий нарийн бичгийн даргын хүсэлтээр энэхүү Хэлэлцээрийн Оролцогч талуудын эрх бүхий байгууллагууд өөрийн нутаг дэвсгэрт Дүрэмд заасан хуралдаан, түүнчлэн ОУЭЦБ-Интерполоос зохион байгуулж буй бусад бага хурал, уулзалтын үеэр ОУЭЦБ-Интерпол, Гишүүн орнуудын төлөөлөгчид, ОУЭЦБ-Интерполын тодорхой байгууллагуудын гишүүд болон ОУЭЦБ-Интерполын албан тушаалтнуудын аюулгүй байдлыг хангахад шаардагдах бүх талын арга хэмжээг авна.
2. Энэхүү Хэлэлцээрийн Оролцогч талууд нь өөрсдийн нутаг дэвсгэрийн хүрээнд ОУЭЦБ-Интерполын албан тушаалтнуудын хувийн аюулгүй байдлыг хангах, осол эндэгдлээс сэргийлэх, аливаа халдлагаас хамгаалах болон саадгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн бүхий л боломжит арга хэмжээг авна.
3. Энэхүү Хэлэлцээрийн Оролцогч талууд нь өөрсдийн нутаг дэвсгэрийн хүрээнд ОУЭЦБ-Интерполын байрыг аливаа халдлага, заналхийлэл, хохирлоос хамгаалах, мөн байр байгууламж амгалан тайван байдлыг алдагдуулахгүй байх, ОУЭЦБ-Интерпол болон түүний албан тушаалтнуудын нэр хүндэд халдахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бүхий л боломжит арга хэмжээг авна.

14 дүгээр зүйл
Эрх ямба, дархан эрхээс татгалзах

1. Энэхүү Хэлэлцээрийн дагуу олгож буй эрх ямба, дархан эрх нь тухайн этгээдийн хувийн ашиг сонирхлын төлөө бус, харин ОУЭЦБ-Интерполын эрх ашигт нийцүүлэн олгогдсон болно. Дархан эрх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулж болохуйц нөхцөлд ОУЭЦБ-Интерполын эрх ашгийг хөндөхгүйгээр түүнээс татгалзах боломжтой бол Ерөнхий нарийн бичгийн дарга нь ОУЭЦБ-Интерполын аливаа албан тушаалтнаа дархан эрхээс татгалзах эрхтэй байхын сацуу ингэх үүрэг хүлээнэ. Хэрэв Ерөнхий нарийн бичгийн даргын дархан эрхээс татгалзах асуудал хөндөгдвөл үүнийг ОУЭЦБ-Интерполын Ерөнхий Ассамблей шийдвэрлэнэ.
2. Татгалзаж байгаагаа ямагт тодорхой илэрхийлсэн байвал зохино.



3. Дархан эрх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулж болохуйц нөхцөлд тухайн дархан эрхийг олгосон зорилгыг хөндөхгүйгээр татгалзах боломжтой бол Оролцогч талууд өөрсдийн Төлөөлөгчдийн дархан эрхээс татгалзах эрхтэй байхын сацуу ингэх үүрэг хүлээнэ.
4. Эрх ямба, дархан эрх эдэлж буй бүх этгээд ийм эрх ямба, дархан эрх эдлэх эрхээ хөндөхгүйгээр нутаг дэвсгэрт нь байгаа тохиолдолд тухайн Оролцогч талын хууль, журмыг хүндэтгэн сахих үүрэгтэй.
5. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, цагдаагийн байгууллагын журмын биелэлтийг хангах, мөн энэхүү Хэлэлцээрт заасан эрх ямба, дархан эрх болон хөнгөлөлтүүдийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх зорилгоор ОУЭЦБ-Интерпол нь Оролцогч талуудын эрх бүхий байгууллагуудтай тогтмол хамтран ажиллана.

15 дугаар зүйл

Гуравдагч талтай үүссэн маргааныг шийдвэрлэх


ОУЭЦБ-Интерпол нь дараах маргаануудыг зохих ёсоор шийдвэрлэх зорилгоор шаардлагатай арга хэмжээг авна:

- (a) ОУЭЦБ-Интерполын оролцож буй гэрээнээс үүдэлтэй маргаанууд. ОУЭЦБ-Интерпол нь гэрээний тайлбар, хэрэгжилттэй холбоотой аливаа маргааныг зөвлөлдөх, зуучлалын журмаар, хэрэв талууд маргааныг эв зүйгээр шийдвэрлэж чадаагүй тохиолдолд талуудын хооронд тохиролцсон арбитрын журмаар шийдвэрлэнэ гэсэн заалтыг тухайн байгуулж буй гэрээндээ тусгана;
- (b) Мэдээллийн нэгдмэл багцыг хянах комисст хандаж шийдвэрлүүлэх боломжтой Интерполын мэдээллийн сүлжээн дэх өгөгдөл боловсруулах үйл ажиллагаатай холбоотой маргаанууд;
- (c) Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Захиргааны шүүхэд шилжүүлж болох ОУЭЦБ-Интерпол болон түүний албан тушаалтнуудын хооронд үүссэн маргаанууд.

16 дугаар зүйл

Оролцогч талуудтай үүссэн маргааныг шийдвэрлэх

1. Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах эсхүл хэрэглэхтэй холбоотойгоор хоёр буюу түүнээс дээш Оролцогч тал хооронд, эсхүл нэг талаас ОУЭЦБ-Интерпол болон нөгөө талаас нэг буюу түүнээс дээш Оролцогч тал (тус бүрийг нь "маргалдагч тал", хамтад нь "маргалдагч талууд" гэх) хооронд үүссэн аливаа маргааныг хэлэлцээ хийх, зөвлөлдөх, эсхүл маргаан шийдвэрлэхээр тохиролцсон бусад аргаар шийдвэрлэнэ.
2. Хэрэв маргаанд оролцогч талууд өөрөөр тохиролцоогүй бол энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах эсхүл хэрэглэхтэй холбоотойгоор үүссэн, энэ зүйлийн нэг (1) дүгээр хэсгийн дагуу шийдвэрлэх боломжгүй аливаа маргааныг тухайн маргаанд оролцогч аль нэг талын хүсэлтээр, энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурахад нээлттэй болох өдрөөр хүчин




төгөлдөр байгаа Олон улсын арбитрын шүүхийн “Олон улсын байгууллага, улс хоорондын арбитрын маргааныг хянан шийдвэрлэх сайн дурын дүрмүүд”-ийн дагуу эцсийн бөгөөд заавал биелүүлэх арбитрын журмаар шийдвэрлүүлнэ. Маргаанд оролцогч талуудын хэлэлцээрт үндэслэн арбитрчийн тоо нэг эсхүл гурав байна. Нэг арбитрч томилогдох бол маргаанд оролцогч талууд түүнийг харилцан тохиролцож томилно. Хэрэв тохиролцож чадаагүй бол Олон улсын арбитрын шүүхийн Ерөнхий нарийн бичгийн дарга томилно. Хэрэв Арбитрын шүүх гурван гишүүнээс бүрдсэн бол маргаанд оролцогч тал тус бүр нэг арбитрчийг томилж, томилогдсон хоёр арбитрч нь гуравдагч буюу даргалагч арбитрчийг харилцан тохиролцож томилно. Хэрэв тохиролцож чадаагүй бол Олон улсын арбитрын шүүхийн нарийн бичгийн дарга томилно. Нэр дэвшигч арбитрч нь томилогдохоосоо эсхүл албан үүргээ эхлүүлэхээс өмнө хүлээн зөвшөөрөх, бэлэн байдал, шударга байдал болон хараат бус байдлын мэдэгдэлд гарын үсэг зурна. Арбитрын шүүхийн шийдвэр нь ОУЭЦБ-Интерпол болон маргаанд оролцогч тал эсхүл талуудын хувьд эцсийн бөгөөд заавал биелүүлэх хүчин төгөлдөр шийдвэр байна.

3. Арбитрын ажиллагааны хэл нь ОУЭЦБ-Интерполын албан ёсны хэл болох араб, англи, франц, эсхүл испани хэлний аль нэг нь байна.
4. Маргалдагч талуудын аль нэг нь хуулиар тогтоосон дүрэм, журам болон эрх зүйн бусад үүргийн дагуу мэдээллийг заавал ил болгох нөхцөлөөс бусад тохиолдолд маргалдагч талууд болон арбитрын бүрэлдэхүүн нь арбитрын ажиллагаа явагдаж буй эсэх болон талуудын ирүүлсэн бүх тайлбар, баримт бичиг, аливаа шийдвэр, арбитрын шийдвэр зэргээр үл хязгаарлагдах арбитрын ажиллагааны агуулгыг чанд нууцална. Хэрэв мэдээллийг ил болгох шаардлага үүсвэл тухайн маргалдагч тал мэдээллийг задруулахаас өмнө нөгөө тал болон бусад маргалдагч талуудтай зөвлөлдөнө.

17 дугаар зүйл

Нэмэлт, өөрчлөлт оруулах

1. Аливаа Оролцогч тал энэхүү Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргаж болох бөгөөд ингэхдээ Ерөнхий Ассамблейн дараагийн чуулганы нээлтээс дор хаяж 120 хоногийн өмнө ОУЭЦБ-Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргад хүсэлт илгээнэ.
2. ОУЭЦБ-Интерполын Ерөнхий нарийн бичгийн дарга хүсэлтийн бүрдэл бүрэн эсэх болон тогтоосон хугацаанд ирүүлсэн эсэхийг хянан. Хэрэв эдгээр шаардлагыг хангасан бол Ерөнхий нарийн бичгийн дарга нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Ерөнхий Ассамблейн хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулах хүсэлтийг Гүйцэтгэх хороонд хүргүүлж, Ерөнхий Ассамблейн дараагийн чуулганы нээлтээс дор хаяж 90 хоногийн өмнө нийт Гишүүн орнуудад түгээнэ.
3. Зөвшилцөлд хүрч чадаагүй нэмэлт, өөрчлөлтийг Ерөнхий Ассамблейн чуулганд хүрэлцэн ирж, санал өгсөн Оролцогч талуудын тавны гурвын олонхын саналаар батлах бөгөөд ингэхдээ нийт Оролцогч талуудын олонх санал хуралтад байлцсан байхыг шаардана.
4. Ерөнхий нарийн бичгийн дарга ийнхүү баталсан аливаа нэмэлт, өөрчлөлтийг нийт Оролцогч талууд болон гарын үсэг зурсан улсуудад хүргүүлнэ.



5. Нэмэлт, өөрчлөлтийг баталсан орнуудын тавны гурав нь соёрхон баталсан эсхүл хүлээн зөвшөөрсөн батламж жуух бичгээ ОУЭЦБ-Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулснаас хойш 60 хоногийн дараа уг нэмэлт, өөрчлөлт нь түүнийг соёрхон баталсан буюу хүлээн зөвшөөрсөн Оролцогч талуудын хувьд хүчин төгөлдөр болно.
6. Шаардагдах тооны соёрхон баталсан буюу хүлээн зөвшөөрсөн тухай батламж бичгүүдийг хадгалуулсны дараа нэмэлт, өөрчлөлтийг соёрхон баталж буй эсвэл хүлээн зөвшөөрч буй Оролцогч тал бүрийн хувьд тухайн нэмэлт, өөрчлөлт нь өөрийн батламж бичгээ хадгалуулсан өдрөөс хойш 60 дахь хоногт хүчин төгөлдөр болно.
7. Нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болсны дараа энэхүү Хэлэлцээрийн Оролцогч тал болсон Улс өөр санаа зорилго илэрхийлээгүй бол түүнийг:

(a) Нэмэлт, өөрчлөлт орсон хэлбэрээр энэхүү Хэлэлцээрийн Оролцогч тал гэж үзнэ;

b) Нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөөгүй Оролцогч талуудтай харилцах бол нэмэлт, өөрчлөлт ороогүй Хэлэлцээрийн Оролцогч тал гэж тооцно.

18 дугаар зүйл


Тайлбарлах

1. Энэхүү Хэлэлцээр дангаар хэрэгжихдээ Интерполын Үндсэн хууль, түүний Ерөнхий журам болон хавсралтуудын аливаа заалтыг цуцлах эсхүл түүний үйлчлэлийг сулруулах үндэслэл болохгүй.
2. Энэхүү Хэлэлцээрийн аливаа заалт нь Оролцогч талууд энэхүү Хэлэлцээрийн заалтуудыг баталгаажуулах, нэмэлт оруулах, хүрээг өргөжүүлэх, эсхүл танах, өөрчлөх, эсхүл ач холбогдлыг нэмэгдүүлэх зорилгоор ОУЭЦБ-Интерполтой бусад хэлэлцээр байгуулах эрхийг хязгаарлахгүй.
3. Энэхүү Хэлэлцээрийн заалтууд ОУЭЦБ-Интерполын Төв байр, Бүс нутгийн товчоо, эсхүл ОУЭЦБ-Интерполын бусад байр аль нэг Оролцогч талын нутаг дэвсгэрт байршиж буйтай холбогдуулан ОУЭЦБ-Интерпол болон тухайн Оролцогч талын хооронд байгуулсан олон улсын хэлэлцээрийн заалтуудыг хязгаарлахгүй бөгөөд хөндөхгүй. Энэхүү Хэлэлцээр болон дээр дурдсан хэлэлцээр хооронд зөрчил үүссэн тохиолдолд дээр дурдсан хэлэлцээрийн заалтуудыг баримтална.

19 дүгээр зүйл

Гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, болон нэгдэн орох

1. Энэхүү Хэлэлцээр нь Ерөнхий Ассамблейгаар батлагдсан өдрөөс хойш хоёр жилийн хугацаанд ОУЭЦБ-Интерполын Гишүүн орнууд гарын үсэг зурахад нээлттэй байна.
2. Энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурсан Улс орнууд түүнийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, эсхүл батлах шаардлагатай. Соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, эсхүл баталсан тухай батламж бичгийг ОУЭЦБ-Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.



3. Энэхүү Хэлэлцээр нь нэгдэн ороход нээлттэй хэвээр байна. Нэгдэн орсон тухай батламж бичгийг ОУЭЦБ-Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

20 дугаар зүйл
Хүчин төгөлдөр болох

1. Энэхүү Хэлэлцээр нь түүнийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай тав дахь батламж бичгийг хадгалуулсан өдрөөс хойш 30 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.
2. Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш түүнийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл түүнд нэгдэн орсон улсын хувьд ийнхүү соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон батламж бичгээ ОУЭЦБ-Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулснаас хойш 30 дахь өдөр Хэлэлцээр хүчин төгөлдөр болно.

21 дүгээр зүйл
Төгсгөлийн заалтууд

1. Оролцогч тал энэхүү Хэлэлцээрийн зорилго, зорилтод нийцсэн нөхцөлтэйгөөр тайлбар хийж болно. Зөвхөн соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон батламж бичгийг хадгалуулах үед тайлбарыг хийх бөгөөд Ерөнхий нарийн бичгийн дарга энэ талаар ОУЭЦБ-Интерполын нийт Гишүүн улсад нэн даруй мэдээлнэ.
2. Хэрэв Оролцогч тал ОУЭЦБ-Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргад Хэлэлцээрийг цуцлах тухай мэдэгдэл ирүүлсэн бол уг мэдэгдлийг Ерөнхий нарийн бичгийн дарга хүлээн авснаас хойш зургаан сарын дараа энэхүү Хэлэлцээрийн үйлчлэл тухайн Оролцогч талын хувьд дуусгавар болно. Ингэхдээ энэхүү Хэлэлцээр нь ОУЭЦБ-Интерпол болон соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон батламж бичгээ хадгалуулсан бусад улс хооронд хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.

22 дугаар зүйл
Эх хадгалагч

ОУЭЦБ-Интерполын Ерөнхий нарийн бичгийн дарга нь энэхүү Хэлэлцээрийн хадгалагч байна.

ДЭЭРХИЙГ ГЭРЧИЛЖ, тус тусын Засгийн газраас зохих ёсоор бүрэн эрх олгогдсон доор гарын үсэг зурсан Төлөөлөгчид энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурав.

2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Мароккогийн Вант Улсын Марракеш хотноо араб, англи, франц болон испани хэлээр үйлдэв. Хэл тус бүрээр үйлдсэн эх бичвэрүүд нь адил хүчинтэй байх бөгөөд ОУЭЦБ-Интерполын архивт хадгалагдана. Ерөнхий нарийн бичгийн дарга нь эх хувийн баталгаат хуулбарыг гарын үсэг зурсан болон нэгдэн орсон бүх улсад хүргүүлнэ.

